



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 50, 52, 53 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Зам, тээврийн салбарын шагнал олгох журам"-ыг нэгдүгээр, зам, тээврийн салбарын шагналд тодорхойлох иргэний анкетын загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Шагналын үнэмлэх, гэрчилгээ, тэмдэг хэвлүүлэх болон холбогдох бусад зардлыг байгууллагынхаа төсөвт төлөвлөж, зарцуулахыг харьяа агентлаг, байгууллагын дарга /захирал/ нарт зөвшөөрсүгэй.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Ж.Гантөмөр/-т үүрэг болгосугай.


4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн сайдын 2012 оны 96 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.ГАНБАТ

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны
06. дугаар сарын 27-ны өдрийн 134 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын зам, тээврийн салбарыг хөгжүүлэхэд олон жил үр бүтээлтэй ажиллаж, бодитой хувь нэмэр оруулсан болон тухайн салбарт онцгой амжилт бүтээл гаргасан салбарын ажилтан, албан хаагч, иргэн мөн гадаад улсын иргэнийг Засгийн газрын болон Зам, тээврийн хөгжлийн яамны шагналаар шагнаж урамшуулах, тэдгээрийн тэмдэг, үнэмлэхийг нөхөн олгоход энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Зам, тээврийн салбарын шагналын төрөл

2.1. Зам, тээврийн салбарын шагнал нь Засгийн газрын 1997 оны 50, 52, 53 дугаар тогтоолд заасны дагуу дор дурдсан төрөлтэй байна.

2.1.1. Засгийн газрын шагнал:

- "Автотээврийн тэргүүний ажилтан"
- "Онц тээвэрчин",
- "Хүндэт төмөр замчин",
- "Тэргүүний замчин",
- "Иргэний агаарын тээврийн тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг

2.1.2. Зам, тээврийн хөгжлийн яамны шагнал:

- "Хүндэт дэвтэр"-т бичигдсэн тухай дурсгалын гэрчилгээ,
- Яамны "Хүндэт жуух бичиг"

2.1.3. Гадаадын иргэнд олгох зам, тээврийн салбарын шагналын үнэмлэх, гэрчилгээг англи хэл дээр хэвлэсэн байна.

Гурав. Шагнал олгох болзол

3.1. Зам, тээврийн салбарын шагналаар шагнахад дор дурдсан үзүүлэлтийг харгалзан үзнэ. Үүнд:

3.1.1. Зам, тээврийн салбарын ажил, үйлчилгээг боловсронгуй болгох дэвшилтэт техник, технологи, шилдэг арга ажиллагаа нэвтрүүлэн ажил үйлчилгээний чанар, нэр төрөл, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлсэн тодорхой үр дүн, үр бүтээл;

3.1.2. Салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд бодитой хувь нэмэр оруулсан, салбарын хөгжилд онцгой үр дүн өгөхүйц эрдэм шинжилгээ, судалгааны шинэ нээлт, бүтээл туурвисан;

3.1.3. Зам, тээврийн салбарт онцгой амжилт гаргасан болон шинэ бүтээл, оновчтой санаачилга гаргасан, тодорхой үр дүн бүхий бүтээлч ажил хийсэн. /энэ тохиолдолд онцгой амжилт гаргасныг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар,;/

3.1.4. Салбартаа амжилт гарган тогтвортой ажиллаж, амжилт бүтээл нь хамт олон, үйлчлүүлэгч, мэргэжлийн хүмүүст үнэлэгдсэн, мэргэжлийн өндөр ур чадвар, туршлагатай;

3.1.5. Байгууллагын соёл, үнэт зүйлийг эрхэмлэн, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэхэд үлгэрлэгч байх;

3.2. Автотээврийн салбарт 15 болон түүнээс дээш жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, автотээврийн салбарт ажил хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан, тухайн байгууллагад 3 жил тогтвор суурьшилтай ажилласан жолоочийг “Онц тээвэрчин” хүндэт тэмдгээр;

3.3. Автотээврийн салбарт 15 болон түүнээс дээш жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, автотээврийн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулан, ажил хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан, тухайн байгууллагад 3 жил тогтвор суурьшилтай ажилласан уг журмын 3.2 дахь заалтад тодорхойлсноос бусад албан хаагч, иргэнийг “Автотээврийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр;

3.4. Төмөр замын тээврийн салбарт 15 болон түүнээс дээш жил ажилласан, төмөр замын тээврийн салбарт ажил хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан, тухайн байгууллагад 3 жил тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч, иргэнийг “Хүндэт төмөр замчин” хүндэт тэмдгээр;

3.5. Авто замын салбарт 15 болон түүнээс жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, авто замын салбарт ажил хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан, тухайн байгууллагад 3 жил тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч, иргэнийг “Тэргүүний замчин” хүндэт тэмдгээр;

3.6. Иргэний агаарын тээврийн салбарт 15 болон түүнээс дээш жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, иргэний агаарын тээврийн салбарт үнэтэй хувь нэмрээ оруулж, хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан, тухайн байгууллагад 3 жил тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч, иргэнийг “Иргэний агаарын тээврийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнана.

3.7. Зам, тээврийн салбарт 25-аас доошгүй жил ажилласан, салбарын үйл ажиллагаанд ажил бүтээлээрээ онцгой амжилт гаргасан, бүтээл болон ажил нь олон нийт, төрд өндрөөр үнэлэгдсэн, төрийн дээд цолоор шагнагдсан албан хаагч, иргэнийг “Хүндэт дэвтэр”-т бичиж алдаршуулна ;

3.8. Улсад 10 жил, зам, тээврийн салбарт 5 болон түүнээс дээш жил идэвх зүтгэлтэй ажилласан, тухайн байгууллагад 3 жил тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч, иргэнийг яамны “Хүндэт жуух бичиг”-ээр шагнаж урамшуулна.

3.9. Зам, тээврийн салбарын шагналыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар олгоно.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

- 4.1. Зам, тээврийн салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа ажилтан албан хаагч, тухайн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад ажилтан, уг салбарт хамаарагдах төрийн албан хаагчийг үндсэн байгууллага нь шагналд тодорхойлно.
- 4.2. Аль нэг байгууллага, аж ахуйн нэгжид харьяалагддаггүй ахмадуудыг оршин сууж буй сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газраас болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, бусад олон нийтийн байгууллагаас тодорхойлж болно
- 4.3. Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа байгууллагуудын салбар нэгжүүдээс шагналд тодорхойлохдоо зөвхөн үндсэн байгууллагаар дамжуулан, тухайн харьяа байгууллагын дарга, захирал нар тодорхойлно.
- 4.4 Төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, бусад олон нийтийн байгууллагаас Зам, тээврийн салбарын аль нэг байгууллагад ажилладаг албан хаагчийг шагнуулах санал дэвшүүлсэн тохиолдолд тухайн хүний ажиллаж байгаа байгууллагаас заавал санал авсан байна.
- 4.5. Зам, тээврийн салбарын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүний ажил байдлын тодорхойлолтод нийт ажилласан хугацааны ажлын амжилт, үр бүтээл, салбарт оруулсан хувь нэмэр, шагнуулах үндэслэлийг тодорхой бичиж, ажлын үзүүлэлт, нээлт бүтээлийн жагсаалтыг хавсаргаж, байгууллагын дарга гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулсан байна.
- 4.6. Зам, тээврийн салбарын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлж буй хүмүүсийг тодорхойлохдоо дор дурдсан материалыг бүрдүүлнэ. Үүнд:
 - 4.6.1. шагнуулахаар нэр дэвшүүлсэн тухай байгууллагын албан бичиг;
 - 4.6.2. сайдын тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан загвар анкет;
 - 4.6.3. хамт олны эсхүл удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл
 - 4.6.4. ажил байдлын тодорхойлолт /ажлын үр дүнгийн үзүүлэлт, бүтээлийн жагсаалтыг хавсаргах/;
 - 4.6.5. өмнө шагнагдсан шагналуудын хуулбар;
 - 4.6.6. онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар;
 - 4.6.7. нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар /Зөвхөн нүүр, ажилд авсан болон чөлөөлсөн хэсэг/
- 4.7. Шагналд нэр дэвшүүлсэн хүний материалыг тухайн шагналыг олгох баяр, ойн өдөр болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө яаманд ирүүлнэ.

4.8. Энэхүү журмын 3.1.3-т заасан үзүүлэлтээр шагнагдах хүмүүст ажилласан жилийг хамааруулахгүй.

4.9. Зам, тээврийн салбарын шагналаар шагнуулахаар тодорхойлохдоо өмнө нь авсан шагналаас хойших 3-аас доошгүй жилийн ажлын ололт амжилт, үр бүтээл, үр дүнгийн ахисан төвшингийн үзүүлэлтийг харгалзах.

Тав. Шагналыг шийдвэрлэх, олгох

5.1. Яамны Төрийн захиргааны удирдлагын газрын шагнал урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн холбогдох байгууллагуудаас шагнуулахаар нэр дэвшүүлэн ирүүлсэн баримт бичгийн бүрдэлт, агуулгыг судлан, санал боловсруулж, шийдвэрийн төслийг Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга нарт танилцуулсны үндсэн дээр шагнал олгох асуудлыг Сайдын тушаал гаргаж шийдвэрлүүлнэ.

5.2. "Салбарын тэргүүний ажилтан", "Жуух бичиг"-ээр Монгол Улсын Үндэсний их баяр наадам, Цагаан сар, Их эзэн Чингис хааны өдөр, Шинэ жилийн баяр, салбарын ажиллагсадын өдрүүдээр шагнах бөгөөд энэхүү журмын 3.1.3-т заасан заасан үзүүлэлтийг үндэслэн шагнах тохиолдолд энэ хугацаа хамаарахгүй байж болно.

5.3. "Хүндэт дэвтэр"-т Монгол Улсын үндэсний их баяр наадам, Цагаан сарыг тохиолдуулан бичиж, гэрчилгээ олгоно.

5.4. "Хүндэт дэвтэр"-т бичигдсэн тухай дурсгалын гэрчилгээ олгох ажиллагааг яамны Төрийн захиргааны удирдлагын газар тусгайлан зохион байгуулна.

5.5. "Салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг, "Жуух бичиг"-ээр шагнагдсан хүмүүсийн шагналыг тухайн хүний ажилладаг салбараас шалтгаалан Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа агентлаг, салбар байгууллагууд дээр шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулж, хүндэтгэлтэйгээр гардуулна. Хөдөө орон нутагт оршин суудаг иргэдийн шагналыг яамны харьяа агентлаг, салбар байгууллагуудын хөдөө орон нутгийн салбаруудаар дамжуулан олгоно.

5.6. Журмын 3 дугаар зүйлд заасан болзол шаардлагыг хангаагүй, баримт бичгийг 4.5-д заасны дагуу бүрдүүлээгүй тохиолдолд шагнал олгохгүй.

5.7. Шагнагдсан болоод шагнагдаагүй хүмүүсийн баримт бичгийг буцаан олгохгүй бөгөөд архивын нэгж болгон хадгална.

5.8. "Салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг, үнэмлэх болон яамны "Хүндэт жуух бичиг"-ийг үрэгдүүлсэн буюу гэмтээсэн тохиолдолд нөхөн олгож болох ба дараах баримт бичгийг бүрдүүлэн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт хандана:

5.8.1 Тэмдэг, үнэмлэх нөхөн олгохыг хүссэн өргөдөл;

5.8.2 Иргэний үнэмлэхийн хуулбар;

5.8.3 Шагналын үнэмлэхийн хуулбар;

5.8.5 Мөнгө тушаасан баримт;

5.9. Шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн өргөдлийг хянан үзээд хүндэт тэмдэг, үнэмлэх, "Жуух бичиг"-ийг нөхөн олгох үндэслэлтэй гэж үзвэл хэвлүүлсэн зардлыг холбогдох байгууллага, иргэнээс гаргуулсны дараа олгоно.

Зургаа. Шагналын сан бүрдүүлэх, зарцуулах

6.1. Зам, тээврийн салбарын шагналын санг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

6.1.1. Шагнал урамшилд зориулсан улсын төсөв;

6.1.2. Батлагдсан урсгал төсвийн хөрөнгийн хэмнэлт;

6.1.3. Бусад эх үүсвэр

6.2. Зам, тээврийн салбарын шагналын дагалдах мөнгөн шагналыг Засгийн газраас тогтоосон хэмжээгээр олгох ба "Салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгийн дагалдах мөнгөн шагнал 100000 /Нэг зуун мянган/ төгрөг, яамны "Жуух бичиг"-ийн дагалдах мөнгөн шагнал 10000 /Арван мянган/ төгрөгийг шагналд нэр дэвшүүлсэн байгууллага, аж ахуйн нэгж нь, "Хүндэт дэвтэр"-т бичигдсэн тухай дурсгалын гэрчилгээг дагалдах мөнгөн шагналыг Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгоно. Гадаадын иргэнд дагалдах мөнгөн шагнал олгогдохгүй.

Долоо. Шагналын мэдээллийн сан


7.1. Салбарын хэмжээнд шагналын талаарх мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, баяжилт хөдөлгөөн хийх асуудлыг яамны шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтэн хариуцна. Үүнд:

7.1.1. Энэхүү журмын дагуу Зам, тээврийн салбарын шагналаар шагнагдсан иргэдийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх;

7.1.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журмыг батлах тухай" 1999 оны 71 дүгээр зарлигийн дагуу Монгол Улсын цол хүртсэн, одон, медалиар шагнагдсан зам, тээврийн салбарын ажиллагсдын мэдээлэл;

7.1.3. Монгол Улсын Засгийн газрын "Засгийн газрын хүндэт өргөмжлөл, гэрчилгээний тодорхойлолт, дүрэм батлах тухай" 1997 оны 51 дүгээр тогтоолын дагуу Засгийн газрын "Хүндэт өргөмжлөл"-өөр шагнагдсан зам, тээврийн салбарын ажиллагсдын мэдээлэл.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны
06... дугаар сарын 27-ны өдрийн 24 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ШАГНАЛААР ШАГНАГДАХ ИРГЭНИЙ АНКЕТ

/загвар/

/Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар олгох зам, тээврийн салбарын шагналд өргөн мэдүүлэх хүний анкетыг бөглөхдөө доорх загварыг баримтална./

1. Овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр
2. Регистрийн дугаар
3. Хүйс
4. Боловсрол, мэргэжил
5. Үндсэн захиргаа
6. Ажилладаг салбар
7. Урьд болон одоо ажиллаж байгаа газар

Зураг 4х6

№	Ажлын газрын нэр	Эрхэлсэн ажил	Хугацаа
	Нийт ажилласан жил		

8. Төр, Засгийн болон бусад ямар шагналаар хэзээ шагнагдсан:

№	Шагналын нэр	Шагнагдсан он /заавал бичнэ/

9. Шагнуулах гэж байгаа үндэслэл /тухайн хүний ажлын амжилт, гаргасан үр дүн, туурвисан бүтээл зэргийг сүүлийн 5 жилээр тодорхой бичиж, шаардлагатай гэж үзвэл холбогдох жагсаалтыг хавсаргана/

.....
.....

.....
.....
.....
.....
.....
10. Ямар шагналаар шагуулах:
.....
.....
.....

11. Хамт олны саналын хувь:
.....
.....

БАЙГУУЛЛАГЫН ДАРГА /ЗАХИРАЛ/ -ЫН ГАРЫН ҮСЭГ,
ТАМГА / ТЭМДЭГ